



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/343

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны
“Энх энэрэл” өрхийн эрүүл мэндийн төвийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 6,952,260 (зургаан сая есөн зуун тавин хоёр мянга хоёр зуун жар) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны “Энх энэрэл” өрхийн эрүүл мэндийн төв (Г.Ууганцэцэг)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 5 нэр төрлийн 3,460,700 (гурван сая дөрвөн зуун жаран мянга долоон зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 5 нэр төрлийн 3,491,560 (гурван сая дөрвөн зуун ерэн нэгэн мянга таван зуун жар) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 24,000 (хорин дөрвөн мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 7,200 (долоон мянга хоёр зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны “Энх энэрэл” өрхийн эрүүл мэндийн төв (Г.Ууганцэцэг)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн А/343 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны "Энх энэрэл" Өрхийн эрүүл мэндийн төв

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил			Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүнгэлт	Байгууллагын Үнийн санал	НӨХТ мэргэжилтний Үнийн санал	ЭБХХК-ын шийдвэр
		Ш	М	Д									
Тоног төхөөрөмж													
1	Хөлий массажны аппарат	12	ш	1	95,000.0	95,000.0	95,000.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
2	Нурууны массажны аппарат	12	ш	1	70,000.0	70,000.0	70,000.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
3	Асер компьютер	12	ш	2	689,900.0	1,379,800.0	1,379,800.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
4	Samsung 220 канон принтер	12	ш	1	215,900	215,900.0	215,900.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
5	Acer E270 компьютер	11	ш	2	755,830.0	1,511,660.0	1,511,660.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	5,000.0	5,000.0
6	Угаалгын машин	7	ш	1	279,900.0	279,900.0	279,900.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	4,000.0	4,000.0
7	Шээсний шинжилгээний аппарат	6	ш	1	1,700,000.0	1,700,000.0	1,221,874.8	478,125.2	Сэлбэг байхгүй	актлах	актлах	устгах	устгах
8	Суурин компьютер (core\)	7	ш	1	850,000.0	850,000.0	850,000.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	5,000.0	5,000.0
9	Төмөр хашаа	7	м2	6.4	85,000.0	544,000.0	380,799.4	163,200.7	НТХО-аар гадна тохижилтын ажил	актлах	актлах	5,000.0	5,000.0
10	Төмөр хаалга	7	м2	3.6	85,000.0	306,000.0	214,200.0	91,800.0	хийж шинэчилсэн	актлах	актлах	5,000.0	5,000.0
					Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				-	-	-	24,000.0	24,000.0
					Үүнээс Худалдах хөрөнгө								
					Актлах хөрөнгө								
					Татан төвлөрүүлэх хөрөнгө								
					Худалдсанаас олох орлого								
					НӨХТ-т төвлөрүүлэх 30%								
					24,000.0								
					7,200.0								